

ДИСКУРС АНАЛИЗЫГ УЛС ТӨРИЙН ОРЧУУЛГЫН ТЕКСТЭД АШИГЛАХ НЬ

О.Мөнхчимэг⁶⁸

Abstract: *Procedures of translating and interpreting unto different languages from source are existed since the origin of first language. Language itself and the usages in the process of development highly influenced to others on purpose as well as are essentially inseparable with translation and has become the most important tool for expressing opinions and thoughts up to the present. The written format for languages is less much weaker comparing to the spoken ones on persuasion as observed. For one and certain example, the people, citizens and voters tend to not spend time with reading political journals, articles and so forth, but would rather watch television, radios, social medias in modern time as the paper is focused on translation methods in political contexts, and mostly they are willing to express view of political status through those medias – brought much impact on political environment, election procedures or decisions of policymakers.*

All those processes are vitally relevant to whether speaker fulfills the aims of the speech or influenced or not, the percentages of influences to the targeted audiences. Directly, the speaker is being responsible carefully for using the most appropriate words, phrases and expressions, more, the body language says what he says and what he emphasize. For instance, any speeches may consist of numbers of hand gestures, movements, sounds or voices, intonations, rhetorical speech acts and facial expressions to the public. In which speeches reach to the people meant success for accomplishing the aims for voters. Those help strengthen political status, attracting the supporters orally and written ways, at the same time, those and both texts and speeches are with discourse having certain aims of speakers to the audiences; thus in order to translate those materials or the interpretation itself must keep the precise disciplines, complying with practical situations while having deep knowledge of own culture and language with respect by introducing wide and diverse range of world cultures to the people – the issue what emphasized in the paper based on the examples of political texts under the topic of translation methods and discourse analysis.

When translating properly the mental and cognitive understandings of the texts, accurate and disciplined duties nationwide are highlighted. Furthermore, in the process of interpretation and translation, the aims hidden in the text or speech must be well informed to the audiences – that is the discourse what we are exploring currently – meaning beyond the word, expression, phrases, and sentences and all those say how the translation qualifies.

Key words: *Translation methods, and techniques, political discourse, translation experience, discourse analysis, speech with purpose.*

⁶⁸ О.Мөнхчимэг

E-mail: Munkhchimeg.O@Humanities.mn

Албан тушаал: ХИС, Хэл, соёлын сургууль, Англи хэлний тэнхимийн багш, Докторант

Удиртгал

Орчуулга судлалын үүднээс дэлхий нийтийг холбох улс төрийн харилцааны үндсэн хэрэгсэл нь хэл болсон цагаас аваад улс төрийн шинжлэх ухаан нь хэлтэй салшгүй холбоотой байсаар иржээ. Улс төрийн хөгжил, өөрчлөлтийг дагаж, хэл, хэлний хэрэглээ даган өөрчлөгддөг хэмээн үзсэн байдаг. (Fairclough 2000).

Зөвхөн илтгэл нийтлэл, ярилцлагыг ойлгохоосоо илүүтэйгээр хэлэх гэсэн санааны үндсэн агуулга, төгсгөл хэсэг нь сонсогчдод хэрхэн хүрч байгаа нь таамаглал дагуулсаар иржээ. Энэ нь зөвхөн нэг хэлээр ярилцагчдын хувьд төдийгүй, олон хэл дамжсан, орчуулгын үүрэг оролцоотой үед аливаа текст бичвэр, аман илтгэл нь бусдад яг яригчийн хэлсэнтэй ижил хэлний хэрэглүүрийг ашигладаггүй тул хүн бүрийн санаа бодлоо илэрхийлэх байдал өнгө аяс, үгийн сонголт, хэлэхүйн үйлдлүүд сонсогчдод хүрэхдээ харилцан адилгүй. Энэ ч утгаараа сонсогчид нь яригч, илтгэгчдийн илэрхийлэл, санаа бодлыг ойлгохгүй байх дискурсын үл зөрчил үүсэх нь бий.

Учир нь яригч, илтгэгч, тэр дундаа улс төрийн зүтгэлтнүүд нь өөрийн үзэл санааг яриа, өгүүлэмжээрээ илэрхийлж, бусдад ойлгуулах, тухайн нийгмийн үйл явцыг өөрийн өнцгөөс тайлбарлан, түүнд нөлөөлөх оролдлого хийдэг. Ихэнхдээ тэдний дискурс нь нийгэмд болж буй үйл явдлыг эерэг тал руу хандуулах гэсэн оролдлого гэж харагдах бөгөөд үүндээ тэд хэлийг өөрсдийн улс төрийн байр суурийг илэрхийлэх, үндсэн хэрэгсэл, зэвсэг болгон ашигладаг. Харин энэхүү өгүүллээр зөвхөн Монгол хэлэнд үүсэх асуудал төдийхнөөр хөндөн авах бус, даяарчлагдаж буй энэ нийгэмд дэлхийн улс үндэстний хэмжээнд, тэдгээр хүчирхэг их гүрнүүдийн асуудлыг ойлгоход хүртэл бидэнд орчуулгын асуудал чухлаар тавигдах тул хэл, дискурс илэрхийлэл, орчуулгазүйн асуудал нь салшгүй уялдаатай болж ирнэ. ‘Дискурс шинжилгээ’ хэмээх ойлголтыг Австрийн хэл шинжээч Рут Водакын үзэж буйгаар өөр өөр журам, зарчимд баригдсан нэр томъёог багтаасан нэгэн бүхэл утга гэж үзжээ. (Wodak, Krzyżanowski 2008: 4). Дискурс нь гол объект биш авч, тухайн дискурс яриа явагдахад харилцаа бүрэлдэн тогтож, текст бичвэр, утга, яригчид нөлөөлөх гол хүчин зүйлийг дискурс судална. (Ibid., p.5).

Дээрх ойлголтоос үзэхэд аливаа нэг сэдвийн хүрээнд явагдаж буй зорилготой илтгэл, хэлэлцүүлэг, ярилцлага нь дискурс гэж ойлгож болохоор байна. Түүнчлэн энэхүү шинжилгээг явуулахад тусгайлсан илтгэлийг задлан шинжилж, тухайн илтгэлийг олон нийтэд хүргэж буй шалтгаан, нөхцөл, тухайн агуулгыг сонсогчдод хүргэж буй илэрхийлэл, бусад орчуулга, найруулга зүйн асуудлыг хамтатган үзнэ. Энэ ч үүднээс дискурс бүтээх, түүнийг ойлгох тухай ойлголт нь тухайн контекст/санаа гэдэг ойлголтоос салшгүй хамааралтай болж ирэх юм. (Van Dijk in Wodak & Chilton, 2005, p. 71).

Ван Дейк, Водак, Чилтон нарын эрдэмтдийн үзэж буйгаар тухайн хэлээр ярилцагч ард түмний хувьд зөвхөн “дэлхий ертөнцийн мэдлэг”-ийг түгээхээс

гадна, тусгайлсан нөхцөл байдалд мэдлэгээ амилуулах, уг мэдлэг нь бусдын мэдлэгийн хүрээнд хэрхэн ойлгогдох байдлаар тайлбарлана. Өөрөөр хэлбэл яригчийн илтгэлийг сонсогч, хүлээн авч буй тал мэдлэгийн хүрээнд дискурс утгыг ойлгон, хариу үйлдэл үзүүлж буй байдлаар харилцаа бий болж, дискурсын үндсэн зорилго биелж буй гэж үзнэ. (Van Dijk in Wodak & Chilton, 2005, p. 72)

Орчин цагт дискурс анализ судлалын өнөөгийн судалгаа нь сонгуулийн компанит ажил, сонгуульд нэр дэвшигчдийн илтгэл, хэлэмж, уриа, лоозон, бусад үзэл суртлын асуудалд илүүтэй авч үзэх болжээ. Тиймээс энэхүү судалгааны ажлаас өөр өөр академик боловсрол, ажлын туршлага, түүхэн намтар, зан байдал, ертөнцийг үзэх үзэл, хандлагаараа ялгаатай, хоорондоо ижил бус улс төрчдийг судлагдахуун болгон авч үзэж болно. Энэ дагуу шаардлагатай дата мэдээллийг цуглуулан, зэрэгцүүлсэн байдлаар судалгааг эхлүүлж, тэдний хэлэмжийн түвшинд гарсан үзэл суртал, сонсогчдыг ухуулан сэнхрүүлэх, санаа бодлоо илэрхийлэхдээ ашиглаж буй үзэл суртлын дискурс бүтцийг шинэчлэн тавилаа. Үүний гол асуудал нь Монголын төдийгүй дэлхийн нэрт улс төрчдийн тавьсан илтгэл, нийтлэл, ярилцлага, хэлэлцүүлэг дээр ажилласан гэдэг утгаараа орчуулгын үүрэг нөлөө нэн тэргүүний асуудал болон тавигдаж буй юм. Тэгвэл энэхүү өгүүлэлд монгол, англи хоёр хэлний онцлох ялгаа, тэдгээрийн онцлог шинжийг улс төрийн орчуулгад тусгах нь тухайн хэлний үг хэллэг сонгох, найруулга зүй, хэлзүйн зөв бүтцийг тогтоож, орчуулгын хэм хэмжээг боловсронгуй болгох тал дээр чухал гэдгийг олон судлаачдын хувийн туршлага, эрдэмтэн мэргэдийн санал, судалгаанд хөндөн тавьдаг. Аливаа эх материалыг орчуулахад чухлаар онцлох нэг зүйл бол дискурс буюу зорилготой яриа, далд утга, хэлэхүйн үйлдлийн тусламжтайгаар илэрхийлж гаргаж буй санааг яг тухайн яригч, илтгэгчийн хувилбар байдлаар орчуулгад шингээх асуудлыг онцгойлон анхаарах нь чухал юм. Түүнчлэн энэхүү судалгааны гол зорилго болсон тэдгээр нэр бүхий улс төрчид, нэр дэвшигчдийн ашиглаж буй үзэл суртлын стратеги, эрх мэдлийн холбоо хамаарал, ятган сэнхрүүлэх арга техник зэргийг судалсны үндсэн дээр тэдний хүрсэн амжилт ололт, ялагдал уналтад нөлөөлж буй хамгийн чухал хүчин зүйлсийг тогтооход оршино. Аливаа эх мэдээллийг орчуулахдаа утга санааг гээгдүүлэхгүй, нэмэлт шинэ санааг илэрхийлэхгүй байх нь орчуулгазүйн үндсэн зарчим билээ. /НьюМарк, 2008./

Иймээс дискурс шинжилгээ нь хэлний хэрэглээнд өөрчлөлт оруулах, өөрийн эрх мэдлээ ашиглан нийгэмд нийгмийн хийгээд соёлын өөрчлөлт бий болгоход чиглэгддэг, иймд дискурс анализ нь салбар хоорондын шинжлэх ухаанд тусгайлсан үүрэгтэй (Fairclough, 1992:72). Дискурс анализ нь улс төрийн ярианы хийгээд бичгийн текстийг задлан шинжлэх дискурс судлалын салбар ухаан юм (Fairclough, 1995).

Үүнээс дүгнэн үзэхэд дискурс шинжилгээ нь аливаа илтгэлийн хам сэдвийн хүрээнд гаргах дискурсын нийгэмд үзүүлж буй практик үзэгдэл, үйл явдал, эх бичвэр, нийгэм, соёлын өргөн хүрээний асуудлыг судлах хэл шинжлэлийн нэгэн арга хэрэгсэл гэж хэлж болохоор байна. Улс төр, нийгмийн хүрээнд авч үзвэл дискурс судалгаа нь орчуулгазүйтэй уялдсанаар олон хэлний эх

бичвэр, хам сэдвийн хүрээнд илтгэлийн агуулгаас тухайн яригчийн эрх мэдэл, манлайллын хүрээ, зүй тогтлыг бичгийн болоод ярианы орчуулгын төвшинд судлан шинжилж, хэл хоорондын илэрхийллийн ялгаа, соёлын өвөрмөц онцлог, дискурс задлал зэргийг нэгэн дор судлах боломжийг олгодог гэж хэлж болох юм.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Дээрх дискурс анализ (ДА) нь аливаа улс төрийн сонгуулийн үр дүнг тайлбарлах, задлан шинжлэх арга техник байдлаар хэрэглэгдсээр ирсэн. Дискурс анализын арга техникүүд нь сонгууль, улс төрийн нөхцөл байдалд тодорхой нэг асуудал, зөрчилдөөн, хүндрэлтэй байдлыг хөндөн, чиг шугамыг тогтооход чиглэгдсэн хэл шинжлэлийн үүднээс тухайн өгүүлэмж, илэрхийлэлд гаргаж буй санаа, утгыг тайлбарлах арга хэрэгсэл болгон ашигласаар иржээ. Үүнд: уриа, үзэл суртлын хувьд аваад үзвэл дискурс судлал нь илүүтэй хөндөгддөг. Орчуулгын арга зүйн техник хуучрахгүй, харин орчуулагчийн бүтээлээр улам бүр арвижин тэлж байдаг. Тэгвэл улс төрийн текст орчуулгад тавигдах ерөнхий шаардлага нь эх хэлний нөлөө, хоёрдогч хэлний хэлзүйн мэдлэг, нэн ялангуяа, найруулга зүй, үг сонголт зэргийг түлхүү онцолж үздэг ч энэ удаагийн судалгааны өгүүллээр улс төрийн сэдэвтэй бичвэрүүдийг судалгааны объект болгон авч үзээд тухайн бичвэрийн дискурс ойлголтын шаардлагыг онолын үндэстэй тодорхойлж байна. Гадны бүтээлүүд болон бусад судалгааны ажлаас үзэхэд орчуулах үйл явц нь тухайн өгүүлбэр, санаагаа илэрхийлэл, сэтгэл хөдлөл, цаад эх материалын хэлэхийг хүссэн далд утгыг/дискурс/ гаргах нь зөвхөн уран зохиолын орчуулгын өнгө аяс, амт, аялгуу, сэтгэл хөдлөлөөр зогсохгүй, бүхий л орчуулгын тухай бүрийн санаа сэдлийг илэрхийлсэн далд утгыг мэдэрч, мэдэж орчуулахын чухлыг онцлов. Орчуулгын техникээс голчлон энэхүү судалгаандаа жишээгээр тодорхойлон оруулснаас гадна орчуулга нь гол санааг орчуулахаас илүүтэй зөв дараалалтай, санаа бүрийг орхигдуулахгүй гаргах асуудал хөндөгдөнө. Ийнхүү орчуулга нь ойлгосноо ярихаас өөр, илүү цогц ойлголт буюу үгийг амилуулах урлаг гэж болж байна. Таамаглалаас авч үзвэл бусдын дискурсээр өөрсдийн дискурсын давуу талыг тогтоож буй улс төрийн нам, нэр дэвшигчид тухайн улс төрийн тэмцэлд ялалт байгуулж, сонгуульд ялагдсан тал сонгуулийг орхидог хуультай. Тиймээс эргээд дискурс нь сонгуульд хамгийн зөв шийдвэрийг гаргаж, нэр дэвшигчдийн чадвар, чадамж, тэдний жинхэнэ мөн чанарыг олоход ард олон сонгогчдод тусалдаг. Энэ ч утгаараа, бидэнд улс төрийн ойлголт, улс орны өнөөгийн нөхцөл байдал, чухлаар тавигддаг. Монголын орчуулгын олон зууны түүхэн хугацаанд орчуулан буулгах арвин туршлага, сан хөмрөгөөс уудлан, орчин цагийн орчуулгын арга техник, хандлагатай хослуулан дэлхий нийтийн орчуулгын зөв хандлагыг төлөвшүүлэхэд олон талын сэдэв, чиглэл, салбарыг хамарч уян хатан байдлаар судалгааг явуулахад улс төрийн текст илүү байсан нь энэхүү ажилд орчуулгазүйн асуудлыг дискурс судлалтай холбох туршлагыг бий болгосон юм.

Улс төрийн салбар ухаанд авч үзвэл илүү олны саналыг хүртэж буй дискурс гэдэг нь нийгэм олон нийтийн шалгуур, нийгэмд үүсээд буй голлох асуудлыг хөндөн

тавьж буй илтгэгчийн санаа бодол гэж үздэг бөгөөд түүнд ямар хариу арга хэмжээ авах мөрийн хөтөлбөр дэвшүүлж буй гэдгээс сонгуулийн үр дүн шууд нөлөөлнө. Иймд сонсогчдыг өөртөө итгүүлэх, дискурс санааг ойлгуулах тал дээр сэтгэлгээний түвшинд дискурс шинжилгээ боловсруулахад орчуулгын хэрэгцээ зайлшгүй гардаг. Энэ утгаараа дискурс буюу зорилготой эх бичвэрийг орчуулахад зөвхөн хэлшинжлэл төдийгүй, нийгэм судлал, улс төр судлал, сэтгэл судлал зэрэг салбар дамнасан шинжилгээ явуулах шаардлага үүсдэг. Улмаар энэхүү дискурс судалгаагаар хэлшинжлэлийн үүднээс үгээр илэрхийлэн гараагүй хэлэхүйн үйлдлийг тухайн нөхцөл байдалд шинжлэн судлах боломжийг эрэлхийлэн нэр бүхий улс төрчдийн илтгэл, хэлэлцүүлгийг монгол хэлэнд орчуулж, задлан шинжилж, хэл шинжлэлийн зарчмын үүднээс үндсэн тухайн улс төрчдийн уугуул гарал, мэргэжлийн онцлог, нас хүйс, хүүхэд ахуй өссөн орчин, боловсрол, мэдлэг туршлага, хувийн амьдрал, зан байдал, хэнд зориулан ямар сэдвийн хүрээнд юуг хөндөн тавьж буйгаас хамаарч тухайн бичвэрийн өнгө аяс бүхэлдээ өөрчлөгдөх, энэ нь ч эргээд орчуулгын хоёрдогч, гуравдагч хэлэнд хамт буух ёстойг судалгааны явцад илрүүлсэн болохыг үүгээр дурдав. Энэ дагуу судалгааны олж мэдсэн агуулгын хүрээнд онолын үндэстэйгээр тайлбарлахаар оролдсон болно.

Судалгааны явцад буюу орчуулга хийх явцад тухайн сонгон авсан эх бичвэрийн зохиогчийн талаарх үзэл бодлыг уг бичвэр текстээр гаргаж, мөн энэхүү судалгааны материал нь улс төрийн нөхцөл байдлыг тодорхой хүрээнд орчин үеийн улс төрийн нэр томъёо болон бусад дүйцэхүйц тайлбар дээр үндэслэсэн текстийг ойлгох, ойлгуулах, нарийн тодорхой орчуулах аргачлалын дагуу хийгдэж, улс төрийн үзэл баримтлалыг танин мэдэхүйн үүднээс орчуулгын эквивалент хувилбарыг сонгох мэргэжлийн түвшинд орчуулахад чиглэгддэг.

Бичгийн, аман, дохионы хэлний хэрэглээ /нүүрний хувирал, гарын хөдөлгөөн, харц, үйл хөдлөл, дадал зуршил болсон биеийн хэлэмж ярианд хэрхэн илэрч байгаа байдал/ болон бусад чухал тэмдэгтийн хэрэглээ судлалын ерөнхий нэр томъёоллын дагуу боловсруулах нь орчуулгад мөн тавигдах прагматик /хэрэглээний/ ойлголтоос илүүтэй дискурсын түвшинд судлагдах асуудлыг орчуулгын стандартад жишээгээр үзүүлж буй хэрэг юм. Өгүүлбэр, утга санаа, яриа, харилцан яриа зэргийн уялдаа холбоог судалж, уламжлалт хэл шинжлэлийг бодвол, зөвхөн хэлзүйн бус, өгүүлбэрийн цаад утга санааг боловсруулах бичгийн хэлний өгүүлбэрийн хэлзүйн бүтцээс илүүтэй тухайн хүний/яригчийн нийгэм-сэтгэл судлалын онцлогч шинжийг ил болгон, судалгаандаа тусгах нь чухал. Бүх шинжлэх ухааны болон нийгмийн ухааны чиглэлд дискурсийг авч үзэж болох боловч улс төрийн салбар нь хөрвөх боломжтой, өргөн хүрээний чиглэл гэдэг утгаар нь энэхүү улс төрийн бичвэр дээр дискурсын хэрэглээг орчуулгын арга техниктэй харьцуулан боловсруулсан байдаг.

Дүгнэлт

Орчуулгазүйн үүднээс авч үзвэл орчуулгын дадал, мэдлэг, техник зэргийг чухалчлан авч үздэг ч зөвхөн гол санаа орчуулах, ойлгосноо ярихаас илүүтэй, орчуулгын дадал, мэдлэг, аргазүйд зорилготой яриа, эх бичвэрт гаргасан

дискурсын утгын үнэлэмжийг тодотгон тухайн орчуулгадаа шингээх боловсруулахад суралцах нь чухал төдийгүй зөвхөн мэдээлэл, эх бүтээл, яриа, бичвэрийг орчуулах асуудлаас гадна илүү эмх цэгцтэй, үнэн бодит байдлаар, дэс дараалалтайгаар орчуулах хэлэнд буулгахад асар чухал нөлөөтэй гэдгийг үүгээр дурдах нь зүйтэй. Улс төрийн бичвэрийн орчуулгатай холбоотой асуудалд утгыг нарийвчлах, утгыг ерөнхийлөх, санааг эсрэгээр гаргах, утгыг нэмэн дэлгэрүүлэх байдлаар эсвэл эх бүтээлд үг нэмэх, үг орхих, бүхлээр нь өөрчлөх, орхих зэрэг аргууд хөндөгдөхөөс гадна дискурс буюу зорилготой бичвэр, зорилготой яриаг орчуулах асуудлыг орчуулгазүйд тусгайлан авч үзнэ.

Энэхүү судалгаа нь орчуулгын судалгааны салбарт судлаачдын авч үзсэн онолтой уялдуулан холбогдох асуудлууд англи хэл дээрх улс төрийн ярианы, бичгийн бүтээлийг орчуулах арга техник, эргээд орчуулгад улс төрийн дискурсыг ойлгох тухай авч үзсэн. Улс төрийн бичвэрийг орчуулах талаар нарийн жор, тогтсон дэг гэж байхгүй болохыг онцлох нь зүйтэй бөгөөд орчуулгыг хийхдээ соёл, түүх, улс төрийн нөхцөл байдал, тэдгээрийн ач холбогдлыг ойлгож байгаа эсэх нь чухал. Олон төрлийн эх бичвэрийн хувьд “Орчуулга” гэх нэршлийн талаарх судалгаа ихэд хийгддэг ч нийгмийн олон судлаачдын үзэж буйгаар практик ач холбогдол, төрөл зэргээс хамаарч харилцан адилгүй ач холбогдолтой байх нь бий. Ерөнхий мэдлэгийн хүрээнд дискурст ашиглагдах холбоо хамаарал, улс төрийн дискурс, орчуулгын хоорондын харилцааг энэхүү өгүүллээр чухалчлан авч үзлээ. Шинжлэх ухааны судалгаанд орчуулга, хэлмэрчлэхүй, хөрвүүлгийн асуудал нь орчуулагчийн бүтээлч оюуны үйл ажиллагаа, тухайн эх бүтээлийн өөр хэл дээр буусан шууд тусгал болдог тул аливаа мэдээлэлд орчуулгын алдаа мадаг гаргахгүй байх нь амин чухал байдаг тул үүнийг дискурсын судалгаатай уяж өгсөн болно. Иймд орчуулга хийнэ гэдэг нь тэр дундаа улс төрийн текст бичвэр, илтгэл, ярилцлага, хэлэлцүүлэг зэргийг орчуулахдаа хоёр хэлийг сайн мэдээд зогсохгүй, тухайн үндэстэн, ард түмний соёл, сэтгэлгээний онцлогоор зогсолтгүй олон салбарын мэдлэг мэдээлэлтэй, эх агуулгаас хөрвүүлэхдээ хам сэдвийн онцлогоос хамааран орчуулах арга техникт суралцах, хэрхэн эх мэдээллийг анх тавьсан зохиогчийн зорилготой уяж бусад хэл рүү хөрвүүлэх вэ гэсэн асуудлыг хөнддөг тул энэ нь зөвхөн хэлзүйн асуудал төдийгүй, орчуулагчийн мэдлэг туршлага, тухайн зохиогчийн санаа, зоригийг бүрэн ойлгосон эсэхийг илтгэн харуулах чухал үйл явц юм.

Монгол эх сурвалж, материал

1. Батчулуун Д.(2016). Хэлшинжлэлийн удиртгал. Улаанбаатар.
2. Бадамдорж Д.(1997). Орчин цагийн монгол хэлний утга судлал. Улаанбаатар.
3. Б.Бирваа, (2009) Монгол хэл минь хэл биш сэг болох нь ээ хэмээх нийтлэл [3]-ээс түүж бичлээ. Үндэсний шуудан 2009.04.14 № 089
4. Баярсайхан Ё (1989) Монгол хэлний реалийн орчуулгын зарим асуудал (Орчуулах эрдэм №6).
5. Л. Бямбасүрэн (ХИС) Эдийн засгийн дискурс дэх метафор (Монгол,англи хэлний жишээгээр). 2012. 5 дугаар сар

6. Гүрбазар Р. (1996) Орчуулгын онол дадлагын үндэс. Улаанбаатар.
7. Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А. (1983) Орос монгол толь. Улаанбаатар.
8. Дашдаваа Д. (1972). Үндэсний онцлог бүхий үг, хэлц үгийг орчуулах нь. Орчуулах эрдэм №1.
9. Хонгорзул. Т, (2012) Дискурсын үндсэн ойлголтууд
10. Д.Туул, Г.Туяа, Ц.Тунгалаг. (2012) Орчуулгын онол, дадлагын үндэс. Улаанбаатар.
11. Туяа Г. (2004) Хэл соёлын шүтэлцээг цагийн утгаар илэрхийлэх нь. Улаанбаатар, 2004.х.84
12. Туяа Г. (2004) Хэл соёлын шүтэлцээг цагийн утгаар илэрхийлэх нь. Хэл бичгийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.
13. Туул Д., Туяа Г., Тунгалаг Ц. (2001) Орчуулгын онолын дадлагын үндэс. Улаанбаатар.
14. Төмтөгтох Г.(2013) Монгол хэлний үндэсний онцлог үгийн үгийн сан-утгазүйн судалгаа.
15. Хэл бичгийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. (2012). Хэл шинжлэлийн удиртгал. Улаанбаатар.
- 16. Гадаад эх сурвалжаас**
17. Álvarez, Román and Vidal, M. Carmen-África (eds.). (1996.) Translation, Power, Subversion.. Clevedon: Multilingual Matters..
18. Baker, Mona. (2006) Translation and Conflict. A Narrative Account. London and New York: Routledge.
19. Bánhegyi, Mátyás.. (2009). The translator's ideology and the reproduction of superstructure.. Working Papers in Language Pedagogy 3: 28–56..
20. Bell, Allan. (1998). The Discourse Structure of News Stories. In Bell, Allan and Garrett, Peter (eds.), Approaches to Media Discourse, 64–104. Oxford: Blackwell.
21. Fairclough, N. (1995). Critical Discourse Analysis-The Critical Study of Language. London: Longman.
22. Bărbuleț, G. (1918). Discourse Analysis with Michel Foucault & Critical Discourse Analysis with Norman Fairclough. Universitatea, Alba Iulia.
23. Komissarov, Vilen N. (2004). On Linguistic Basis of Creativity in Translation. - La Traduzione.
24. Lyngbak Fogh Holst, June. (2010). Creativity in translation: a study of various source and target texts. PhD thesis. http://pure.au.dk/portal/files/11416/Creativity_in_Translation.pdf
25. Pym, Anthony. (1992). Translation and Text Transfer – An Essay on the Principles of Intercultural Communication. Frankfurt am Main: Peter Lang.
26. Savory, Th. H. (1968). The Art of Translation. - London: Jonathan Cape, Thirty Bedford Square.
27. Schäffner, Christina. (2004) Political Discourse Analysis from the point of view of Translation Studies., Journal of Language and Politics. 3(1): 117–150.
28. Soltani, S. A. A. (2004). Discourse Analysis as a Theory and Method
29. Tang, Jun. (2007) Encounters with Cross-cultural Conflicts in Translation. In Salama-Carr, Myriam (ed.), Translating and Interpreting Conflict, 135–147.. Amsterdam and New York: Rodopi.
30. Ubozhenko, I. V. (2012). The Theoretical Basis of a Linguo-Didactic Model of Developing Creativity in Translation: “Push-Word” Methodology, Prospects for the Neurolinguistic Approach. In: Abstracts of 4th UK Cognitive Linguistics Conference (London: King’s College).